



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Иргэдийн Оролцооны Нэгдэл нам ИОНН-ын
дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд
бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Пүрэвсүрэнгийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэдийн Оролцооны Нэгдэл нам ИОНН-ыг төлөөлж үүсгэн байгуулагч Ц.Оюунгэрэлээс “... Иргэдийн Оролцооны Нэгдэл нам нь 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр ээлжит бус 03 дугаар Их хурлаа хийж, тус хурлаар намын дүрмийг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэх, шинэчлэн найруулах талаар хэлэлцээд намын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг батлаад, танайд ... өргөдөл гаргасан билээ ... 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 38 дугаар тогтоолоор ИОНН-ын өргөдлийг авч хэлэлцээд Улс төрийн намын тухай хуульд дурдсан ... 10 гаруй зүйл, заалтын шаардлагыг хангаагүй байгааг үндэслэн ИОНН-ын дүрмийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан ... ИОНН-ын дүрмийн дагуу Төлөөлөгчдийн Танхимын 2025 оны 01 дүгээр хурлыг зарлан хуралдуулж, Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн үнэмлэхгүй олонхын саналаар намын ээлжит бус 03 дугаар Их хурлаар батлагдсан дүрэм (шинэчилсэн найруулга)-д нэмэлт, өөрчлөлт оруулан хуулийн шаардлагад нийцүүлээ. Иймд ИОНН-ын дүрмийн шинэчилсэн найруулга, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн хамт улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэх хүсэлт, нийт 183 хуудас материал, 1 ширхэг флаш дискийн хамт 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг.Намын дүрмийн өөрчлөлтийн тухайд:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар тусгайлан заажээ.

Хуулийн дээрх заалтыг үндэслэн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 38 дугаар тогтоолын үндэслэх хэсгийн 1-д “... Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрэмд намын гишүүнд “сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг тодорхой заагаагүй ...” гэж дурдсан байна.

Нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг судалж үзэхэд, дүрмийн 4.7-д “Намын гишүүнийг дор дурдсан зөрчил гаргасан нь үндэслэлтэй гэж Маргаан Таслах Комиссын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол гишүүнд намаас хасахыг сануулах, намаас төрийн сонгуульд нэр дэвших эрхийг нэг сонгуулийн жилд хасах, намаас хасах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна” гэж 3 төрлийн сахилгын шийтгэл оногдуулахаар заасан. Гэтэл дүрмийн 4.7.1-4.7.3-т заасан зөрчил нь зөвхөн намаас хасах шийтгэл оногдуулах үндэслэлийг тодорхойлсон бол сануулах болон эрх хасах шийтгэл нь ямар зөрчилд оногдуулахыг намын дүрмээр зохицуулаагүй байх тул дээрх зөрчил арилаагүй гэж үзэв.

2.Иргэдийн Оролцооны Нэгдэл намын Төлөөлөгчдийн Танхимын 2025 оны 01 дүгээр 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит бус 3 дугаар Их хурлаар баталсан дүрэм (шинэчилсэн найруулга)-ийн 365 заалтын 102 заалтад нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Гэтэл Төлөөлөгчдийн Танхимын 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолд тусгагдаагүй доор дурдсан зүйл, заалтуудыг намын дүрэмд нэмж оруулсан зөрүүтэй байдал үүссэн. Үүнд:

2.1.Дүрмийн “5 дугаар зүйл. Намын гишүүн, түүний төрөл”, “8.2.Намын гишүүд нийгэмд тулгамдсан асуудалд намын үнэт зүйлийн хүрээнд шийдэл хайхаар нэгдэж, тодорхой сэдэв, нийгмийн бүлгийн хүрээнд тогтмол бус үйл ажиллагаатай сонирхлын бүлэг, клуб байгуулан ажиллаж болно. Сонирхлын бүлэг, клубын гишүүд нь сайн дурын үндсэн дээр сонирхлын бүлэг, клубыг байгуулах, өөрчлөн байгуулах, нэгдэх, татан буулгах шийдвэрийг гаргах бөгөөд намын удирдах байгууллага, албан тушаалтан тус шийдвэрт оролцохгүй”, “10.11.3.Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг дотоод аудиторыг 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар томилох, чөлөөлөх, нэг удаа улируулан томилох”, “24.6.Нам санхүүгийн үйл ажиллагаандаа энэ дүрэмд заасны дагуу жил бүр хөндлөнгийн санхүүгийн аудит хийлгэж, аудитаас гарсан дүгнэлтийг нийтэд мэдээлнэ. Ингэхдээ Монгол Улсын аудитын тухай хуулийг баримтална”, “26.6.Намын танхим бүхий аль нэг аймаг, дүүрэгт байгуулагдсан бүх салбар татан буугдсан бол тухайн аймаг, дүүргийн танхимыг, нийслэлийн бүх дүүрэгт намын танхим татан буугдсан бол нийслэлийн

танхимыг татан буулгах тушаалыг намын дарга гаргана”, “26.7.Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр байгууллагатай нэгдэх шийдвэрийг тус байгууллагын дүрмээр зохицуулна. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага өөрөө татан буугдсан бол энэхүү дүрмийн дагуу байгуулагдсан бодлогын судалгааны байгууллагыг нам шинээр байгуулж бүртгэж авна” гэж тус тус өөрчилсөн.

2.2.Дүрмийн “14.4.3.Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлаар хуулиар тогтоосон хугацаанд холбогдох хурлыг товлон зарлахгүй, товлон зарласан хуралдаа оролцохгүй байх”, “15.10.Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох талаар намын Төлөөлөгчдийн танхимаас гарсан шийдвэр, хуулиар заасан бусад баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбоотой намын санхүү, хандивын тайланг төрийн зохих байгууллагад хугацаанд нь илгээгээгүй нь Ерөнхий менежерийг огцруулах үндэслэл болно” гэж тус тус нэмэлт оруулсан байна.

Түүнчлэн намын дүрмийн 11 дүгээр зүйлд “11.1”, “11.2” гэсэн дугаарыг давхардуулан дугаарласан, 25 дугаар зүйлд “251” гэж дугаарласан алдааг залруулах шаардлагатай.

Хоёр.Намын дүрэмд өөрчлөлт оруулсан шийдвэр гаргах ажиллагааны тухайд:

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзвэл, ИОНН-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит анхдугаар Их хурлын 04 дүгээр тогтоол, 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хоёрдугаар Их хурлын 04 дүгээр тогтоолын хавсралтуудаар Төлөөлөгчдийн Танхимын нийт 105 гишүүний нэрсийг баталжээ. Харин Төлөөлөгчдийн Танхимын гишүүнээр батлагдаагүй 1 гишүүнийг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр хурлын ирцэд тооцож 106 гишүүний ирцийн бүртгэлийг ирүүлжээ.

Хуралд биечлэн оролцож бүртгэлд гарын үсэг зурсан 6, цахим (зүүм)-аар 30, цахим систем (аппликейшн)-ээр 46, нийт 82 гишүүн оролцсон байна.

Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно” гэж заасан.

Тус намын Төлөөлөгчдийн Танхимын 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлээс үзвэл, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой санал, асуулт явуулж, Төлөөлөгчдийн Танхимын гишүүдээс намын дүрмийн зарим заалтын талаар санал гаргаж, хэлэлцүүлсэн байна. Төлөөлөгчдийн Танхимын гишүүдэд урьдчилан цахим шуудангаар намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хүргүүлсэн хэдий ч хуралдаанд цахим системээр санал өгсөн гэх 46 гишүүдийн оролцоог хэрхэн хангасан нь баримтад тодорхойгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Иймд Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрмийн өөрчлөлтийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас бүртгэх боломжгүй гэж үзэв.

Иргэдийн Оролцооны Нэгдэл нам өөрийн дүрэмд заасан журмын дагуу дахин хуралдаж, дээрх зөрчлүүдийг арилгасны үндсэн дээр Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг шинэчлэн баталж, хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд дахин хандах эрхтэй болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.ПҮРЭВСҮРЭН